



УВС АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/07

Улаангом

Цагдаагийн газрын ахмад настануудад
хүндэтгэл үзүүлэх тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.4, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан "Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам"-ын 136.4.2.-ын "в", "е", "к", мөн даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар баталсан "Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээний тухай /код 947/ журам" -ын 947.4.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. XVII дугаар жарны "Урвуулагч" хэмжээх шороон гахай жилийн хаврын тэргүүн сарын шинийн нэгний баярыг тохиолдуулан тус цагдаагийн газраас тэтгэвэрт гарсан ахмадуудад 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Ахмад настануудад хүндэтгэл үзүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, зохион байгуулахыг Захиргааны удирдлагын тасгийн дарга, /цагдаагийн дэд хурандаа Н.Мишигдорж/-д даалгасугай.

3. Хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаанд зарцуулагдах 2014000 /хоёр сая арван дөрвөн мянган / төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч, /цагдаагийн ахмад Б.Дуламсүрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, /цагдаагийн хошууч Ц.Жамбалдорж/-д даалгасугай.


Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Ч.ЛХАГВАДОРЖ

Цагдаагийн газрын даргын 2019 оны
.....01.....сарын ...31.....өдрийн ...1/07... тоот тушаалын
нэг дүгээр хавсралт



МАТЕРИАЛЫН ТООЦОО

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Хэвийн боов	ш	1800	945	1701000
2	Сүү	ш	2800	45	126000
3	Чацарганы шүүс	ш	5000	20	100000
4	Хадаг	ш	45	2000	87000
НИЙТ ДҮН					2014000

